



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 314

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.5, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дотоод хэргийн их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 10 нэрийн, нийт 83,962,764.00 (наян гурван сая есөн зуун жаран хоёр мянга долоон зуун жаран дөрвөн) төгрөгийн балансын үнэ бүхий 1 дүгээр хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Дотоод хэргийн их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 7 нэрийн, нийт 21,270,000.00 (хорин нэгэн сая хоёр зуун далан мянган) төгрөгийн балансын үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан биет бус хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

3.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Дотоод хэргийн их сургуулийн захирал хошууч генерал Ш.Лхачинжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2.Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг (худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

3.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.4.Сэлбэгээр худалдсан автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 3-дугаар сарын 3-ны өдрийн
31/4 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины нэр, марк, улсын дугаар, арал, хөдөлгүүрийн дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ үнэ (төгрөг)
1	Зил-АЦ, цистерн, 97-36 УБД (арал-170171)	1982/1982	786914	483,300.00	300,000.00
2	Мазда бонго, 14-84 УБД (арал-sd2at601230)	1995/2007	106337	5,036,074.00	169,500.00
3	Хьюндай аксент, 55-03 УБТ (арал-kmhva21nрwu382782)	1998/2008	139499	4,864,020.00	135,000.00
4	Хьюндай аксент, 14-94 УНЕ (арал-kmhva21nрwu381537)	1998/2008	121926	4,864,020.00	135,000.00
5	Хьюндай верна, 28-00 УНМ (арал-kmhcg51fруu048754)	2000/2008	172239	5,211,450.00	135,000.00
6	Асиа комби, 35-89 УБҮ, (kn2dam2c1vk004483)	1997/2009	170133	9,700,000.00	300,000.00
7	Мотоцикль-93-40 УБ (хөдөлгүүр-e3d7e001367, арал-ркe129880015575)	2008/2011		1,787,500.00	50,000.00
8	Уаз-3102, 08-69 ХЦА, (хөдөлгүүр-20303212)	2002/2001	901462	10,130,400.00	270,000.00
9	Паз-32054, 10-39 ХЦА (хөдөлгүүр-71013093, арал-700053035)	1998/2008	431762	29,886,000.00	500,000.00
10	Хьюндай грейс, 12-21 УНХ, (арал-kmifd37bp2k547993)	2002/2012	313380	12,000,000.00	270,000.00
	Нийт дүн			83,962,764.00 (наян гурван сая есөн зуун жаран хоёр мянга долоон зуун жаран дөрвөн)	2,264,500.00 (хоёр сая хоёр зуун жаран дөрвөн мянга таван зуун)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 4-ны өдрийн
314 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Програм /элсэгчдийн бүртгэл/	2014.04.07	1,170,000.00	1	1,170,000.00
2	Бүртгэлийн програм	2015.12.31	1,400,000.00	1	1,400,000.00
3	Бар, код уншигч програм	2014.02.17	800,000.00	1	800,000.00
4	Програм /удирдлагын нэгдсэн/	2014.09.29	3,000,000.00	1	3,000,000.00
5	Програм хангамж /хувцас, хангалтын/	2013.11.25	11,000,000.00	1	11,000,000.00
6	Цаг бүртгэлийн програм	2015.11.16	900,000.00	1	900,000.00
7	Програм хангамж /Э-оффис/	2014.12.31	3,000,000.00	1	3,000,000.00
	Нийт дүн				21,270,000.00 (хорин нэгэн сая хоёр зуун далан мянган)